



УЛААНБААТАР ХОТЫН ШУУРХАЙ УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “ Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 6.1.2, Улаанбаатар хотын нийтийн үйлчилгээний шуурхай зохицуулалтын дүрмийн 3.2.6, 6.1.2.а заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэрэлтүүлгийн “Тулга” системд хариу ирээгүй байгаа алдаатай төлөвүүдийг багасгах, гэрэлтүүлгийн асалт, унтралтанд гарч байгаа зөрчлийг газар дээр нь үзэж арга хэмжээ авч ажиллах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. Ажлыг 2017 оны 4 дүгээр сарын 03-07-ны өдрүүдэд зохион байгуулж, төвийн даргад танилцуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий диспетчер /Б.Дамдинжав/-т даалгасугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Н.Батсүх/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАН - ОЧИР

УБ хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын
төвийн даргын 2017 оны 03 дугаар сарын 28 ны
өдрийн 109 дугаар тушаалын хавсралт



Ажил шалгах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

| | | |
|--------------------------|---------------|--|
| Ажлын хэсгийн ахлагч: | Д.Бауыржан | Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төвийн Ахлах диспетчер- инженер |
| Гишүүд: | Р. Даваасүрэн | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/ |
| | Г.Ганзул | Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төвийн Диспетчер-инженер |
| | Б.Энхсайхан | Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төвийн Програм хангамжийн инженер |
| | П.Золбаяр | Информатик ХХК-ийн захирал |

Гэрэлтүүлэг хариуцсан компанийн захирлууд